

**ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн
захирал, доктор, профессор Л. Хайсандайн
хурлыг нээж хэлсэн үг**

Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь гол чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал байдаг юм. Манай улс энэ чиглэлд ихээхэн ач холбогдол өгч, ХБНГУ, Англи, Франц зэрэг өрнөд Европын өндөр хөгжилтэй орнуудтай хоёр талын төвшинд төдийгүй 1992 оны Маастрихтын гэрээгээр үүсгэн байгуулагдсан Европын Холбооны хүрээнд харилцаа, хамтын ажиллагаа тогтоои хөгжүүлж байна. Цаашид энэ харилцаа холбоогоо улам өргөжүүлэн бэхжүүлэх, үр ашгийг нь улам нэмэгдүүлэн төгөлдөржүүлэх явдал чухлаар тавигдаж байгаа. Энэхүү зорилтын үүднээс Европын Холбоог анх үүсгэн байгуулагчийн нэг, түүний хамгийн идэвхтэй гишүүн ХБНГУ-тай найрсгаар харилцаж хамтран ажиллах өргөн боломж, арга замыг судалж нээн харуулах, түүний хөгжлийн түүхэн замнал, туршлагыг Монгол түмэнд сурталчлан танилцуулах, түүнээс үлгэр жишээ авах, суралцах, Германы зээл тусламжийг улам үр ашигтай болгох зүй ёсны шаардлагын дагуу Монголд Герман судлалыг эрчимтэй далайцтай хөгжүүлэх явдал урган гарч байна. Үүнийг удирдлага болгож, Монголын Герман Судлалын Төвийг төрийн бус байгууллагын /ТББ/ хэлбэрээр ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дэргэд үүсгэн байгуулж ажиллуулах санал санаачлагыг бидний хэдэн эрдэмтэн судлаач гаргаж, өнөөдрийн энэ хурлыг зохион байгуулж байна. Энэ хурал манай улсын Ерөнхий сайд ноён Намбарын Энхбаярын ХБНГУ-д албан ёсны айлчлал удахгүй хийх гэж байгаа түүхэн чухал үйл явдлын үед тохиож буй нь бас бэлэг дэмбэрэлтэй юм.

Манай хүрээлэнгийн дэргэд үүний урьд ийм ТББ байгуулж ажиллуулж ирсэн практик туршлага бий. Тухайлбал АНУ судлал, Хятад судлал, Япон судлалын Төвүүдийг үүсгэн байгуулж үр дүнтэй ажиллуулж байна. Эдгээр нь тухайн орон

судлалын эрдэмтэн мэргэжилтний хүч, мэдлэгийг нэгтгэн төвлөрүүлж, тодорхой сэдэвт ажлыг хийж гүйцэтгэхэд ихээхэн тус нэмэртэй байдаг юм. Өнөөдрийн бидний шинээр үүсгэн байгуулах гэж байгаа энэ Төв ч ийм үр дүнтэй байх болно гэдэгт итгэл төгс байна. Үүгээр ч зогсохгүй энэ Төв цаашид өргөжин бэхжиж, Европын Холбооны хэмжээний судлалын Төв болох их ирээдүйтэй гэж үзнэ.

Чингээд өнөөдрийн энэ зохион байгуулах хурлын ажиллагааг нээснийг мэдэгдье.

Бидний урилгыг хүндэтгэн хүлээн авч, зав чөлөө гарган хүрэлцэн ирсэн Монгол улс дахь ХБНГУ-ын Элчин Сайдын Яамны хоёрдугаар нарийн бичгийн дарга ноён Райнер Нуклес танд болон бусад Герман нөхдөд талархлаа илэрхийлье. Мөн энд хүрэлцэн ирсэн манай эрдэмтэн судлаач, сэтгүүлч та бүхэнд талархаж байгаагаа хэлье.